# “ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөвсгөл аймгийн Галт сумын Зүрх багийн цэцэрлэг бага сургуулийн цогцолборын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2025/131/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Д.Отгонбаяр
Утас: 99385356
Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/244
танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЛТ СУМЫН ЗҮРХ БАГИЙН ЦЭЦЭРЛЭГ БАГА СУРГУУЛИЙН ЦОГЦОЛБОРЫН ЗАХИРАЛ С.НОРОВСҮРЭН ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Галт сумын Зүрх багийн цэцэрлэг бага сургуулийн цогцолборын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд 84,997.0 мянган төгрөгийн цахим кабинет, 18,342.0 мянган төгрөгийн утасгүй интернэтийн сүлжээний байгуулах хөрөнгө оруулалтын ажил хийжээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаатай холбоотой 5,996.0 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Хөвсгөл аймгийн Галт сумын Зүрх багийн цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор нь Боловсролын газрын даргатай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 6 зорилт, 44 арга хэмжээний хүрээнд 80 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **152,860,913.47** | **257,402,042.38** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 76,475,251.26 | 180,883,447.27 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 76,475,251.26 | 180,883,447.27 |
| **3121** | **Төгрөг** | 76,475,251.26 | 180,883,447.27 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 76,475,251.26 | 180,883,447.27 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 76,385,662.21 | 76,518,595.11 |
| **354** | **Хангамжийн материал** | 76,385,662.21 | 76,518,595.11 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 615,054.00 | 615,054.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,311,585.00 | 6,351,585.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 7,520,000.00 | 15,731,637.90 |
| 35460 | Хүнсний материал | 28,278,622.00 | 16,874,417.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 33,660,401.21 | 36,945,901.21 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **696,939,067.18** | **741,698,248.48** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 696,939,067.18 | 741,698,248.48 |
| **392** | **Биет хөрөнгө** | 672,046,233.89 | 716,915,415.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 611,582,213.00 | 611,582,213.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -116,961,629.31 | -136,785,499.11 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 254,159,311.51 | 335,297,254.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -155,873,559.34 | -156,043,645.21 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 69,963,801.72 | 59,057,645.72 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -42,230,571.50 | -36,684,884.18 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 39,695,844.50 | 39,695,844.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -10,932,620.51 | -14,872,902.71 |
| 39217 | Ном | 12,643,443.82 | 5,669,389.22 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 24,892,833.29 | 24,782,833.25 |
| 39301 | Програм хангамж | 440,000.00 | 440,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -119,166.71 | -229,166.75 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 24,572,000.00 | 24,572,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **849,799,980.65** | **999,100,290.86** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **74,458,700.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 74,458,700.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 74,458,700.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 74,458,700.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 74,458,700.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **849,799,980.65** | **924,641,590.86** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 849,799,980.65 | 924,641,590.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 425,791,158.10 | 425,791,158.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 425,791,158.10 | 425,791,158.10 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 398,534,681.99 | 475,218,792.20 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 398,534,681.99 | 400,377,181.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 74,841,610.21 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 25,474,140.56 | 23,631,640.56 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **849,799,980.65** | **999,100,290.86** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **549,605,992.80** | **809,300,165.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **790,592.80** | **15,661,365.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 790,592.80 | 15,661,365.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 790,592.80 | 15,661,365.40 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 790,592.80 | 15,661,365.40 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **548,815,400.00** | **793,638,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 519,315,400.00 | 748,838,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 519,315,400.00 | 748,838,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,500,000.00 | 44,800,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,500,000.00 | 44,800,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **575,346,965.85** | **724,999,339.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **575,346,965.85** | **724,999,339.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 560,493,789.85 | 714,066,311.96 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 352,604,159.57 | 493,910,186.00 |
| 210101 | Үндсэн цалин | 242,908,945.26 | 341,993,576.53 |
| 210102 | Нэмэгдэл | 92,391,962.20 | 149,281,909.47 |
| 210104 | Урамшуулал | 17,303,252.11 | 2,634,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,127,309.17 | 60,447,956.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,298,603.83 | 41,704,750.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,564,541.67 | 4,790,722.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,820,833.76 | 2,429,430.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 654,729.10 | 2,236,346.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,788,600.81 | 9,286,706.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,955,497.50 | 32,088,362.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,880,997.50 | 4,397,362.10 |
| 210302 | Түлш, халаалт | 15,925,900.00 | 27,191,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,148,600.00 | 500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,554,325.00 | 9,911,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 94,000.00 | 454,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,733,200.00 | 5,575,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 315,400.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,300,900.00 | 3,881,700.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 22,110,825.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 48,672,135.00 | 40,809,727.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 100,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 48,572,135.00 | 40,709,727.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,739,000.00 | 3,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,739,000.00 | 3,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,446,900.00 | 2,026,411.60 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,446,900.00 | 2,026,411.60 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 57,394,463.61 | 71,372,368.87 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,705,920.00 | 2,794,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,104,200.00 | 2,970,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 50,584,343.61 | 65,607,368.87 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,853,176.00 | 10,933,028.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,501,776.00 | 9,933,028.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,501,776.00 | 9,933,028.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,351,400.00 | 1,000,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,351,400.00 | 1,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-25,740,973.05** | **84,300,825.44** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 9,459,215.23 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 2,067,830.23 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 7,391,385.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -9,459,215.23 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-25,740,973.05** | **74,841,610.21** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **425,791,158.10** | 25,474,140.56 | **424,275,655.04** | 857,088,953.7 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **425,791,158.10** | **25,474,140.56** | **424,275,655.04** | 857,088,953.7 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -25,740,973.05 | -25,740,973.05 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **425,791,158.10** | **25,474,140.56** | **398,534,681.99** | 849,799,980.65 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **425,791,158.10** | **25,474,140.56** | **398,534,681.99** | 849,799,980.65 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 1,842,500.00 | 1,842,500.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **425,791,158.10** | **25,474,140.56** | **400,377,181.99** | 851,642,480.65 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -1,842,500.00 | 00.00 | -1,842,500.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 74,841,610.21 | 74,841,610.21 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **425,791,158.10** | **23,631,640.56** | **475,218,792.20** | 924,641,590.86 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **548,815,400.00** | **793,638,800.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **548,815,400.00** | **793,638,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 519,315,400.00 | 748,838,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 519,315,400.00 | 748,838,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,500,000.00 | 44,800,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,500,000.00 | 44,800,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **511,924,988.74** | **658,810,303.99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **511,924,988.74** | **658,810,303.99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **495,084,288.74** | **650,286,303.99** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 352,604,159.57 | 493,910,186.00 |
| 210101 | Үндсэн цалин | 242,908,945.26 | 341,993,576.53 |
| 210102 | Нэмэгдэл | 92,391,962.20 | 149,281,909.47 |
| 210104 | Урамшуулал | 17,303,252.11 | 2,634,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,127,309.17 | 60,447,956.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,170,772.49 | 41,653,526.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,527,562.18 | 4,799,315.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,813,230.17 | 2,429,430.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 677,662.91 | 2,278,976.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,938,081.42 | 9,286,706.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,648,600.00 | 40,300,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,500,000.00 | 5,300,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,000,000.00 | 34,500,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,148,600.00 | 500,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 54,633,300.00 | 31,714,550.00 |
| 210502 | Хоол, хүнс | 54,633,300.00 | 31,714,550.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,500,000.00 | 3,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,500,000.00 | 3,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,446,900.00 | 2,026,411.60 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,446,900.00 | 2,026,411.60 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,124,020.00 | 18,387,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,487,420.00 | 14,669,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,636,600.00 | 3,717,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,840,700.00** | **8,524,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,489,300.00 | 7,524,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,489,300.00 | 7,524,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,351,400.00 | 1,000,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,351,400.00 | 1,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **36,890,411.26** | **134,828,496.01** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **14,685,800.00** | **30,420,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **14,685,800.00** | **30,420,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 14,685,800.00 | 30,420,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 14,685,800.00 | 30,420,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-14,685,800.00** | **-30,420,300.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 22,204,611.26 | 104,408,196.01 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 54,270,640.00 | 76,475,251.26 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 76,475,251.26 | 180,883,447.27 |

## 2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 76,475,251.26 | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 825,381,900.00 | 644,430,603.99 | 180,951,296.01 | 78.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 825,381,900.00 | 644,430,603.99 | 180,951,296.01 | 78.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 813,759,100.00 | 636,906,603.99 | 176,852,496.01 | 78.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 623,609,700.00 | 493,910,186.00 | 129,699,514.00 | 79.2 |
| 210101 | Үндсэн цалин | 429,786,300.00 | 341,993,576.53 | 87,792,723.47 | 79.6 |
| 210102 | Нэмэгдэл | 190,811,500.00 | 149,281,909.47 | 41,529,590.53 | 78.2 |
| 210104 | Урамшуулал | 3,011,900.00 | 2,634,700.00 | 377,200.00 | 87.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,241,600.00 | 60,447,956.39 | 16,793,643.61 | 78.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,524,500.00 | 41,653,526.99 | 10,870,973.01 | 79.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,179,100.00 | 4,799,315.91 | 1,379,784.09 | 77.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,089,600.00 | 2,429,430.44 | 660,169.56 | 78.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,089,600.00 | 2,278,976.19 | 810,623.81 | 73.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,358,800.00 | 9,286,706.86 | 3,072,093.14 | 75.1 |
| **2105** | **Нормативт зардал** | 56,722,400.00 | 31,714,550.00 | 25,007,850.00 | 55.9 |
| 210502 | Хоол, хүнс | 56,722,400.00 | 31,714,550.00 | 25,007,850.00 | 55.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,239,000.00 | 2,026,411.60 | 2,212,588.40 | 47.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,239,000.00 | 2,026,411.60 | 2,212,588.40 | 47.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 51,946,400.00 | 48,807,500.00 | 3,138,900.00 | 94.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,228,700.00 | 45,089,800.00 | 3,138,900.00 | 93.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,717,700.00 | 3,717,700.00 | 00.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 11622800.00 | 7524000.00 | 4,098,800.00 | 64.7 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 11,622,800.00 | 7,524,000.00 | 4,098,800.00 | 64.7 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,622,800.00 | 7,524,000.00 | 4,098,800.00 | 64.7 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 825,381,900.00 | 748,838,800.00 | 76,543,100.00 | 90.7 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 748,838,800.00 | 748,838,800.00 | 00.00 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 748,838,800.00 | 748,838,800.00 | 00.00 | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 76,543,100.00 | 00.00 | 76,543,100.00 | 0.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 76,543,100.00 | 00.00 | 76,543,100.00 | 0.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 76,475,251.26 | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 180,883,447.27 | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 17.00 | 17.00 | 00.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 06.00 | 06.00 | 00.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 10.00 | 00.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 44.800,000.00 | 43,800,000.00 | 1,000,000.00 | 97.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 44.800,000.00 | 43,800,000.00 | 1,000,000.00 | 97.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 44.800,000.00 | 43,800,000.00 | 1,000,000.00 | 97.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,000,000.00 | 36,000,000.00 | 1,000,000.00 | 97.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | 100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 32,000,000.00 | 32,000,000.00 | - | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | - | 1,000,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 44.800,000.00 | 43,800,000.00 | 1,000,000.00 | 97.8 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 44,800,000.00 | 43,800,000.00 | 1,000,000.00 | 97.8 |

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 5,996.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэнд 4 зөвлөмж өгсөн.

5.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой алдаа илрээгүй байна.

5.2 Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.3 Албан шаардлага өгөөгүй.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Төсвийн зарцуулалттай холбоотой**

Илрүүлэлт:

Тус сургуулийн захирлын 2024 оны 09 сарын 04 өдрийн Б/83 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад 1,042.0 мянган төгрөгийн урамшууллыг олгохдоо ажлын үр бүтээлийг үнэлсэн хангалттай баримтыг үндэслээгүй байна. Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын 213209 "Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал-Байгууллагын дотоод журамд дагуу албан хаагчид голдуу хагас бүтэн жилийн эцэст нэг удаа олгох мөнгөн шагнал, урамшуулал эсхүл журамд заасан нөхцөлөөр нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна", “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг шагнаж, урамшуулах талаар дотоод журамд зааж, ажлын гүйцэтгэлийг үнэлж, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас олгож байх. Цаашид балансын урамшуулал гэсэн нэр томьёо ашиглахгүй байх

**2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой**

Илрүүлэлт:

Байгууллагын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хянаж үзэхэд төлөвлөгөөнд 4 нэр төрөл дээр 44,800.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн ба тайлангаар 11 нэр төрөл дээр 99,641.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн мэдээлэл байна. Энэ байдлаас харахад худалдан авалтын нэр төрөл тоо хэмжээ, үнийн дүнг үнэн зөв төлөвлөж, тайлагнахгүй байгаа байдалтай байна. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил

үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 , 46 дугаар зүйлийн 46.1 -т заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Зөвлөмж:

Бодитой төлөвлөж, тайлагнаж байх

### 3. ***<u>Худалдан авах ажиллагаатай холбоотой</u>***

*<u>Илрүүлэлт</u>:*

Тус байгууллага нь Гурван цалуу ХХК-тай 27,050.0 төгрөгөөр түлээ, нүүрс нийлүүлэх гэрээ байгуулсан боловч бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж, гэрээний үнийн дүнгээс 4,954,000 төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.2.11-д "гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх" заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх

### 4. ***<u>Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой</u>***

*<u>Илрүүлэлт</u>:*

Тус байгууллага нь Ахмадын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална”, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-тай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль журмын дагуу байгууллагын төсвийн төсөлдөө ахмадын санг төлөвлөн батлуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/Мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нягтлан бодох бүртгэлийн ажилтанд ажлын үр бүтээлийг үнэлэхгүй санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтэд үндэслэн балансын урамшуулал гэж олгосон | 1 | 1,042.0 | | | | | 1 | 1,042.0 |
| Байгууллагын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хянаж үзэхэд төлөвлөгөөнд 4 нэр төрөл дээр 44,800.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн ба тайлангаар 11 нэр төрөл дээр 99,641.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн мэдээлэл байна. Энэ байдлаас харахад худалдан авалтын нэр төрөл тоо хэмжээ, үнийн дүнг үнэн зөв төлөвлөж, тайлагнахгүй байдалтай байна. | 1 | - | | | | | 1 | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Гурван цалуу ХХК-тай 27,050.0 төгрөгөөр түлээ, нүүрс нийлүүлэх гэрээ байгуулсан боловч бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж, гэрээний үнийн дүнгээс 4,954,000 төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна | 1 | 4,954.0 | | | | | 1 | 4,954.0 |
| **Дүн** | **3** | **5,996.0** | | | | | **3** | **5,996.0** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Ахмадын тухай хуулийн дагуу ахмадын сан байгуулж ажиллаагүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |